

## Аюулгүй байдлыг цэргийн аргаар хангах онолын судалгааны өөрчлөлт, хандлага

С.Пүрэвдорж

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Цэргийн урлаг судлалын төв*

### Key words:

Security, war,  
military art, military  
techniques, combat  
equipment, new  
technologies,  
innovation.

### Abstract:

The issue of ensuring security has always been associated with the dangers posed by war and hostilities. It is clear that war, a social phenomenon that has been a constant shadow of the historical development of mankind, has reached the present day. War is a direct reflection of the contradictions in the development of human society, and its nature, content and form are changing, while its characteristics are no longer stable in the process of development.

### Оршил хэсэг

“Дайн бол улс төрийн бодлогыг өөр хэрэгслээр явуулж байгаагаас өөр юм биш”, “дайн бол улс төрийн бодлогын үргэлжлэл”<sup>1</sup> гэж Германы цэргийн онолч К.Клаузевицын өгсөн тодорхойлолт түүний мөн чанарыг танин мэдэх түлхүүр болж байлаа.

Гэтэл “дайн бол улс төрийн бодлогын үргэлжлэл” гэсэн сонгодог үзэл санаагаар, улс гүрнүүд дотоод дахь өнөө үеийн зэвсэгт мөргөлдөөнийг танин мэдэх, тайлбарлахад хүндрэлтэй тулгарч байна. Тиймээс нэлээд олон мэргэшсэн судлаачид “өнөө үеийн дайн бүхнийг улс төрийн тодорхой бодлогын үргэлжлэл хэмээн үзэхэд ихээхэн учир дутагдалтай, XXI зууны улс төрийн бодит байдлыг илэрхийлж чадахгүй байна” гэж үзэж байна. Тухайлбал, Клаузевицын онолд шүүмжлэлтэй ханддаг профессор Мартин ван Кревельд “Дайны хувьсал өөрчлөлт” (Transformation of Warfare) гэсэн бүтээл туурвиж энэ талаар нэлээд эргэцүүлэл хийсэн байна<sup>2</sup>.

Дэлхийн нэртэй судлаачдын нэг болох М.Карвер “1945 оноос хойших дайнууд” (War Since 1945) хэмээх бүтээлдээ, 1945-1980 онд Их Британид хамааралтай явагдсан 16 удаагийн цэргийн мөргөлдөөний 12 нь уламжлалт бус байлдааны ажиллагаа байсныг судалж гаргажээ. Эдгээр нь “сонгодог арга, тактикаар” явагдаагүй бөгөөд 12 мөргөлдөөний 11 нь төрийн бус, цэргийн бус байгууллагын ялалтаар дууссан<sup>3</sup> гэжээ.

Джон Лаффины судалгаанаас үзэхэд, 1980 оноос хойших, тухайлбал зөвхөн 1991 оны 28 удаагийн томоохон мөргөлдөөний 25-ын аль нэг талд

<sup>1</sup> Клаузевиц К. О войне: трактат в 8 томах. - Т. 3. М., 1932. с. 127, 129;

<sup>2</sup> Creveland van, M. Transformation of Warfare. New York, 1991;

<sup>3</sup> Carver, Michael. War Since 1945. New York, 1981;

нь байнгын бус цэргийн байгууллага оролцсон<sup>4</sup> тухай тэмдэглэн үлдээсэн байна.

Дээрхээс харахад, дайны тухай Клаузевицын онолыг өнөө үед тодруулан тайлбарлах шаардлагатай болсон нь ойлгогдож байна. Гэхдээ түүний онолын тулгуур асуудлыг улам бүр сайтар судалж, дайн бүрийн бодлого, учир шалтгааныг олж тогтоох шаардлагатай болж байна.

Тиймээс эртний Хятадын их сэтгэгч Күнз “Дайн тулаан болбоос даяар улсын хэрэг буюу. Олон хүмүүсийн үхэх, сэхэх, улс гэрийн орших, мөхөх нь дайнтай холбоотой учир машид хичээнгүйлэн магадлан эс шинжвээс үл больюу”<sup>5</sup> гэсэн байна.

### **Үндсэн хэсэг**

#### **Нэг. Аюулгүй байдлыг цэргийн аргаар хангах онол**

Дайны аюул, занал байгаа нь ялан дийлэх, дийлэгдэшгүй байхын үндсийг бүрдүүлэхийг улс үндэстэн бүрээс, түүний зэвсэгт хүчнээс шаардах боллоо. Энэхүү ялагдашгүй нөхцөл байдлыг хэрхэн бүрдүүлэх нь судлаачдын хувьд асуудал юм. Дайн бол хамгийн түрүүнд цэргийн хүч хэрэгслээр учруулах аюул. Цэргийн аюулгүй байдлыг хангах цэргийн хэрэгсэл, арга стратегиар хангах нь зүйн хэрэг. Энэ үүднээс асуудлыг судлан үзэхэд, “Дайнд бэлтгэгдэж сургагдсан нь ялалтад хүрэхээс биш, хэн бяр чадалтай нь ялахгүй”<sup>6</sup> гэж Ф.Вегаций сургасан байдаг. Тийм болох нь Вьетнамтай АНУ-ын, Афганистантай ЗХУ-ын, Афганистантай АНУ, НАТО-гийн эвслээс явуулсан дайнуудад өвөрмөц арга, хүч хэрэгслээр дайн, байлдааныг явуулах арга ухаанд суралцсан Вьетнамын болон Афганистаны партизан, тэмцэгчдийн эцсийн үр дүнг харуулсан гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Эндээс харахад, “Цэргийн урлаг нь бүх урлагуудаас хамгийн эрхэм” нь гэсэн алдарт сэтгэгчдийн гаргасан онол, сургаал өнөө үед үнэ цэнээ алдаагүй хэвээр байгаа нь тодорхой юм. Дайн, зэвсэгт мөргөлдөөнд шинжлэх ухаан технологийн хөгжлийг ашигласнаар учруулах хөнөөл, хурд, хүч нэмэгдэж, эдгээрээс шалтгаалан үргэлжлэх хугацаа нь ч мөн өөрчлөгдөх хандлагатай болж, дайн, зэвсэгт мөргөлдөөн нь физик-газар зүйн орон зайнаас хальж кибер, сансрын орон зайд хүрээгээ тэлж, тэмцлийн хэрэгслийн хөнөөх чадвар, алсын тусгал, оноч мэргэн байдал нь байлдааны талбар, стратегийн гүн дэх объект, цэрэг, иргэдийн орших болон амьдрах чадварт хүчтэй нөлөө үзүүлэх боллоо.

---

<sup>4</sup> Laffin, John. *The World in Conflict 1991*. Oxford: Brassey's, 1991;

<sup>5</sup> “Күнзийн дайтахуйн ухаан”. (М. Чимидцэеэгийн орчуулга) 2006 он., т. 22;

<sup>6</sup> Флавий Вегаций Ренат “Краткое изложение военного дела”. / Пер. С.П.Кондратьева. // *Вестник древней истории*. 1940. № 1; переизд.: *Греческие полиоркетик. Вегацій. (Серия «Античная библиотека». Раздел «Античная история»)*. СПб, Алетейя. 1996. 352 стр. с. 153-155;

Зэвсэглэлд гарч буй шинжлэх ухаан, технологийн хөгжлийг гүйцэж, өөрийн улсын зэвсэгт хүчнийг өвч бүрэн зэвсэглэж чадахгүй нь ойлгомжтой учир ялагдахгүй байхын тулд хамгаалалтаа сайжруулахад анхаарах нь зүйн хэрэг. Хамгаалалтаа бэхжүүлж, сайжруулахын тулд *нэгд*, өнөө үеийн “хиймэл оюунд үндэслэгдсэн ухаалаг” зэвсгийг төөрөгдөлд оруулах онолын үндсийг танин мэдэж, тэмцэх арга, хэрэгслээ сонгох; хоёрт, дайн, байлдааны ажиллагаанд ашиглах бодлого, цэргийн стратеги, тактикийн уран аргуудыг сүвэгчилж олох явдал болоод байна.

Энэ нь өнөө үеийн цэрэг, стратегийн сэтгэлгээний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болжээ. Эсрэг талын зэвсэг, хүч, төлөвлөгөөг төөрөгдүүлж, буруу мэдээлэл өгч, өөр зүг рүү анхаарлыг нь татах нь дайнд ялалт байгуулах нэг гол хүчин зүйл болж өгдөг. Үүнийг онолын түвшинд төөрөгдүүлэх стратеги буюу “төлөвлөгөөний далдлалт” гэж нэрлэж байна.

Онолын үндсийг судлан үзэхэд:

1. Сун Зи-ийн “Дайны урлаг” сургаалд “Дайн бол хуурч мэхлэх урлаг мөн”<sup>7</sup> гэж заадаг. Энэ бол төөрөгдүүлэх онолын хамгийн эртний суурь ойлголт юм.

Цэргийн төөрөгдөл үүсгэх стратегид:

- Далд байдал, нууцлалт (stealth);
- Хуурамч байршил, хуурмаг давшилт;
- Мэдээллийн дайн (information warfare);
- Хуурамч мэдээлэл тараах (disinformation).

Тэмцэх аргын хувьд:

1. Мэдээллийн үнэн зөвийг нягтлан шалгах - тагнуул, сөрөх тагнуулын системийг боловсронгуй болгож сайжруулах;

2. Олон эх сурвалжаас мэдээлэл авах - тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, логикийн хувьд зөрчилтэй эсэхийг шалгах;

3. Сургалт бэлтгэл, сургуулилт - цэргийнхэн, командлагчдыг төөрөгдүүлэлт таних чадварт сургах;

4. Технологийн хэрэглээ - хиймэл оюун, анализын системийг ашиглаж бодит мэдээллийг ялган таних.

Цэргийн стратеги, тактикийн уран аргууд:

- Мэхлэх ажиллагаа (Deception Operation): Тухайлбал, 1944 онд Холбоотнуудын “Operation Fortitude” нь Германчуудыг Нормандын оронд Кале рүү довтлох гэж байна гэж итгүүлсэн жишээ байна.
- Хуурамч дохиолол (Fake signals): Холбоо мэдээллийн хэрэгсэл, цахилгаан сүлжээг ашиглан буруу дохио өгөх.
- Хуурмаг байрлал барих (Decoy forces): Жинхэнэ цэрэг техникээ нуун

<sup>7</sup> “Дайны урлаг” (Хятад: 孫子兵法) Сун Цзы (Сун Зи);

далдалж, хуурамч зэвсэг техник байрлуулах ажиллагааг багтааж болох байна.

Улс орноо батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх арга замуудын нэг нь цэрэг-дипломатын арга яах аргагүй чухал юм. Чухамхүү үүнээс улбаалан НҮБ болон олон улсын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөлөл – цэргийн баг, цэргийн алба хаагчид оролцож байгаа гэж үздэг.

Дайны аюулыг багасгах, аюулгүй байдлыг хангах цэргийн аргын нэгдүгээрт цэргийн арга ухаан буюу стратеги, тактик багтана. Сүнз хэлэхдээ “Цэрэглэн дайтахуйн арга ухаан хэмээвээс дайсны улсыг даяар нь дагаар оруулахуй болбоос дээд мэргэн ухаан буюу, улс гүрнийг уулгалан довтолж мөхөөхүй болбоос удаах зэрэг буюу”, “Дайсны түмтийг даяар нь дагаар буулгаж авбаас дээд мэргэн ухаан буюу, довтлон мөхөөхүй болбоос дараа зэрэг буюу...”<sup>8</sup>, гэсэн гоц ухааны үзэл баримтлалыг НТӨ IY-Y зуунд гаргаж тавьжээ. Энэ утгаар дайнаас учруулах аюул занал хувьсан өөрчлөгдөж, дайнгүйгээр ялалт байгуулдаг болсныг “хүйтэн дайн”-ы туршлага, сургамж олонтоо харууллаа. Ийм хэлбэрийн “хүйтэн дайн” цаашид хэлбэр агуулга, шинж чанараа өөрчлөн явагдах нь тодорхой байна.

#### **Хоёр. Аюулгүй байдлыг цэргийн аргаар хангах онолын өөрчлөлт, хандлага**

Дайн, энхийн ялгаа зарим талаар бүдгэрч тайван цагт дайны бус цэргийн ажиллагаа системтэй явуулж зөвхөн цэргийн хүчээр биш улс орны бүх төрлийн хүч хэрэгслийг ашиглан хосолмол дайн, саарал бүсийн дайн, “терроризмын дайн”, “мэдээллийн дайн”, “сэтгэл зүйн дайн”, “төлөөллийн дайн”, “эдийн засгийн дайн”, “геноцидын дайн” гэх мэт олон төрөл, хэлбэр, агуулгатай тэмцэлд ялагдахгүй байхыг улс орон бүр онцгойлон анхаарч судлах боллоо.

Технологийн хөгжлийн эцэг гэгддэг Элон Маск, Билл Гэйтс нар хиймэл оюун хүн төрөлхтний оршихуйд аюул учруулж болзошгүй анхааруулж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин технологид тэргүүлсэн нь дэлхийг удирдана гэж хэлсэн нь ирээдүйн дайны шинж чанарыг тодорхойлох нэгэн өгөгдөхүүн болж байна. БНХАУ гэхэд л 2030 он гэхэд хиймэл оюунаар дэлхийд тэргүүлэгч болно гэсэн стратегиа албан ёсоор зарлаж, түүнийг дайтах урлагтаа нэвтрүүлж эхлэв. Саарал бүсийн дайны нэгэн жишээ нь БНХАУ-ын зүгээс Тайванийн эсрэг явуулж буй үйл ажиллагаа, учир нь ХАЧА-ийн “хязгаарлалтгүй дайн”, “гурвалсан дайн”-ны стратегитай нийцэж байгааг харуулах боллоо. Мөн өнөө үеийн дайныг сүлжээнд тулгуурласан, хямрал, эмх замбараагүй байдалд үндэслэсэн шинж чанарыг агуулсан нь ирээдүйн дайны шинж, төрхийг тодорхойлж болохоор байна.

<sup>8</sup> “Күнз дайтахуйн ухаан”. М.Чимидцэеэгийн орчуулга. 2006 он. т. 27;

XIX, XX зууны ойлголтоор, дайнд ялан дийлэх хэрэгсэл нь зэвсэгт хүчин, арга ухаан нь цэргийн урлаг (стратег, оператив, тактик) байлаа. Өнөө үеийн “хүйтэн дайн”-д ялагдахгүй байх хэрэгсэл, арга ухаан нь юу байж болох вэ гэдэгт хариулт шаардлагатай болжээ.

Өнөө үеийн “хүйтэн дайн”-ны тухай ойлголт нь уламжлалт зэвсэгт мөргөлдөөний бус, харин геополитикийн өрсөлдөөн, мэдээллийн дайн, эдийн засгийн хориг, технологийн давуу тал зэргээр илэрдэг хямралт байдал болоод байна. Ийм нөхцөлд “ялагдахгүй байх” гэдэг нь зүгээр нэг зэвсэг барих бус, ухаалаг бодлого, нэгдмэл стратеги, ухаалаг зөөлөн хүч (soft power) ашиглахыг шаарддаг.

Доорх түүхэн жишээнүүдээр тулгуурлан өнөө үеийн “хүйтэн дайн”-д ялагдахгүй байхын хэрэгсэл, арга ухааныг задлан шинжилж тайлбарлая.

1. Мэдээллийн давуу тал - “Оюун санааны зэвсэг”:

Жишээлбэл, АНУ-ын “Америкийн дуу хоолой”, BBC, Хүйтэн дайны үеийн суртал ухуулга (“Voice of America”, BBC, Cold War-era Propaganda).

Хүйтэн дайны үеэр барууны орнууд ЗХУ-ын эсрэг “мэдээллийн дайн”-ыг амжилттай ашигласан. Ардчиллын үнэ цэнэ, зах зээлийн эдийн засгийн ашиг тусыг олон нийтэд хүргэх зорилготой радиогийн нэвтрүүлэг, ном, сонин зэрэг нь ихээхэн нөлөө үзүүлсэн байдаг.

Өнөө үеийн хэрэгсэл:

- Мэдээллийн үнэн зөв, хурдтай түгээлт;
- Соёлын экспорт (кино, дуу хөгжим, спорт, загвар гэх мэт);
- Хуурамч мэдээлэлтэй тэмцэх дотоод бүтэц (fact-checking network).

2. Технологи, инновац - давуу байршлын үндэс:

Жишээлбэл, АНУ ба ЗХУ-ын сансрыг эзэмших уралдаан.

АНУ ба ЗХУ сансрын уралдаанаар дамжуулан технологийн чадамж, инновац, инженерийн хүч, чадавхаа харуулж, дэлхийд хэн нь манлайлагч болохыг тодорхойлох зорилготой байв.

Өнөө үеийн хэрэгсэл:

- Хиймэл оюун, квант технологи, кибер аюулгүй байдал;
- Өндөр технологийн экспорт, стратегийн хөрөнгө оруулалт;
- Дотооддоо судалгаа, хөгжүүлэлтийг хөхиүлэн дэмжих.

3. Эдийн засгийн уян хатан байдал ба тогтвортой тогтолцоо:

Жишээлбэл, Маршаллын төлөвлөгөө (Marshall Plan)

Дайны дараа АНУ нь Европын орнуудыг сэргээхийн тулд Маршаллын төлөвлөгөөг хэрэгжүүлж, эдийн засгийн хамаарлыг бий болгож, коммунизмыг сөрөн зогссон.

Өнөө үеийн хэрэгсэл:

- Түнш орнуудтай эдийн засгийн харилцан хамааралтай болох;
- Эдийн засгийн хориг, боомилохыг тэсвэрлэх дотоод бүтэц;
- Эрчим хүч, хүнс, түүхий эдийн хангамжийг бие даан шийдвэрлэх чадамж.

4. Зөөлөн хүч (Soft power) болон соёл, урлагийн дипломат харилцаа: Жишээлбэл, Япон, Өмнөд Солонгосын “K-Culture”.

Япон, Өмнөд Солонгос зэрэг орнууд хүчирхэг цэргийн хүчин биш ч, соёл, хөгжим, кино, загвараараа дэлхийд нөлөөлж, зөөлөн хүчний бодлогыг амжилттай хэрэгжүүлсэн.

Өнөө үеийн хэрэгсэл:

- Кино, контент экспортлох;
- Гадаадын оюутнуудыг татах бодлого;
- Үндэсний соёлоо дэлхийд таниулах кампанит ажил.

5. Геополитикийн эвсэл, холбоотон татах стратеги:

Жишээлбэл, НАТО, Варшавын гэрээ

Хүйтэн дайны үед том гүрнүүд эвсэл байгуулж, цэргийн болон стратегийн түншлэлийг бэхжүүлсэн. Хамгийн сайн жишээ бол НАТО.

Өнөө үеийн хэрэгсэл:

- Улс, бүс нутгийн хамтын ажиллагаа (BRICS, ASEAN гэх мэт);
- Хөрш орнуудтай стратегийн түншлэл;
- Олон улсын хууль, эрх зүйн зохицуулалтад идэвхтэй оролцох.

Эндээс харахад, өнөөгийн “хүйтэн дайн”-д зэвсгийн хүч биш, харин мэдлэг, мэдээлэл, технологи, эдийн засаг, соёлын нөлөөлөл ялалтад хүргэнэ. Улс орны дотоод эв нэгдэл, тогтвортой хөгжил, олон улсын тавцанд хэрхэн ухаалаг оролцож чадаж байна вэ гэдэг л шийдвэрлэх болоод байна.

Цэргийн урлаг нь цэргийн аюулгүй байдлыг хангах, тогтоон барих, ялалт байгуулахад чиглэгддэг бөгөөд цэргийн аюулд өртөгдөх аюул, занал дор хөгжиж, хувьсан өөрчлөгддөг зүй тогтолтой билээ. Энэ зүй тогтлыг харгалзах юм бол учирч болзошгүй “хүйтэн дайн”-д ямар хэрэгслээр, ямар стратеги, тактикийн ухаанаар тэмцэх, сөрөн зогсохыг цэргийн хэргийн мэргэжилтнүүд илүүтэй үзэж, цэргийн стратеги, тактикийн онол, практикийг “хүйтэн дайн”-д хэрхэн тодорхойлж ашиглаж болохыг илэрхийлэн гаргажээ<sup>9</sup>. Цэргийн урлагийг бүтээгч хүч хэрэгсэл, арга ухаан хоёр нь өнөө болон ойрын ирээдүйд тохиолдох “хүйтэн дайн”-д илүүтэй ашиглагдана гэж үзжээ.

Эндээс харахад, улс төрийн бодлогын үр дүнгээс дайн гарах, эсэх хамаардаг, улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхэд тохиолдох хүнд асуудлыг өөр арга хэрэгслээр шийдвэрлэж чадахгүйд хүрэхэд, хүчирхийллээр,

---

<sup>9</sup> Паламдорж Ш. “Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хөгжлийн хандлага”. 2011 он;

цэрэг, зэвсгийн хүчээр, дайнаар, өөрт ашигтайгаар шийдвэрлэдэг болохыг шинжлэх ухааны доктор (ScD), профессор Ш.Паламдорж “Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хөгжлийн хандлага” бүтээлдээ гаргажээ.

Харин Мао Цзэдун “улс төрийн бодлого хөгжлийн тодорхой үе шатанд хүрмэгц цаашид урьдын адилаар хөгжих боломжгүй болж, улс төрийн зам дээрх саад бэрхшээлийг арилгахын тул дайн үүсгэнэ”<sup>10</sup> гэсэн тодорхойлолтыг өгсөн байдаг.

К.Клаузевиц, В.И.Ленин нарын тодорхойлолтоор бол “дайн бол цус урсгахыг зөвшөөрч байгаа томоохон ашиг сонирхлын мөргөлдөөн мөн бөгөөд дайн нь зөвхөн үүгээрээ нийгмийн бусад мөргөлдөөнөөс ялгардаг” гэсэн байна.

Дээрх онолын тулгуур ойлголтуудаас харахад, улс төрийн зорилгын мөн чанар нь дайнд ялалт байгуулахад гол нь бус, дайны дараа эрх мэдлийг олж авахад оршдог байна. Хамгийн гол зорилго бол ялалтын дараа ялагдагч талаа өөрийн мэдлийн дагуу залах, удирдах, эрхшээлдээ нийцүүлэн нэгтгэхэд оршиж байна. Өнөө үеийн ардчилсан, хүн төвтэй соёлт нийгэмд булаан эзлэх, дээрэмдэхээс, “найрсаг”-аар өөрийн мэдлийн дагуу залах, удирдах, эрхшээлдээ нийцүүлэн нэгтгэх нь илүүтэй байна.

Өнөө үед бүрэлдэн буй болсон нөхцөл байдлаас улбаалж, тэмцлийн аргуудаас мэдээллийн, терроризмын, даяаршлын, эдийн засгийн гэх мэт тэмцлийн аргууд тэргүүн эгнээнд гарч, харин зэвсэгт тэмцлийн арга удаах зэрэгт, туслах чанарын хэлбэрт шилжих хандлагатай байна.

Хэчнээн ч бай зэвсэгт тэмцлээс бусад аргууд тэргүүлэх байртай болсон ч хамгийн аюултай хүчирхийллийн хэлбэр болох цус асгаруулах халуун дайн үндсэн аюул хэвээр хадгалагдаж байна. Хүч хэрэгсэл нь хомсодсондоо бус, нийгмийн зүгээс, төрийн бус олон нийтийн байгууллагуудаас үзүүлэх эсэргүүцэл, нийгмийн сэтгэл зүйд үзүүлэх нөлөөллөөс сэрэмжлэх нь чухал болой. Эдгээрээс үзэхэд, тэд дайны хүнд бэрхийг хуваалцах, хүний амь нас эрсдэлтэй хэсгийг дуулгавартай холбоотондоо үүрүүлэх тактикт шилжиж байна. Маркс “... ажилчин ангийн санаа сэтгэлийг унагах нь хэчнээн ч удирдагчийн амийг алдсанаас хавьгүй их гай болно”<sup>11</sup> гэжээ.

Ф.Энгельс “Арми” нийтлэлдээ “Арми бол довтлох буюу батлан хамгаалах чиглэлээр дайн хийх зорилгоор төрөөс байлгаж байдаг зэвсэгт хүмүүсийн зохион байгуулалттай нэгдэл”<sup>12</sup> мөн гэжээ.

Ер нь цэргийн хүчин чадавх, цэргийн аюулгүй байдалын хоёрын харилцан хамаарлаас харахад, өнөө үед улс орнууд өөрийн цэргийн аюулгүй

<sup>10</sup> Мао Цзэ-дун. Избранные произведения. Том 3. - М., Издательство иностранной литературы, 1953.- стр.351;

<sup>11</sup> К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. II боть. УБ., 1970. т.488;

<sup>12</sup> К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин “Дайн, армийн тухай”. т. 57;

байдлаа янз бүрээр, арга ухаанаар хангаж байгааг судалж үзэх нь чухал. Тухайлбал, болзошгүй дайсныхаа ямар ч хүчийг илэрхий давамгайлсан цэргийн хүчин чадавхыг бүрдүүлэх, дэлхий, бүс нутагт цэрэг-стратегийн тэргүүлэх байр суурийг хадгалах, батлан хамгаалах зорилгод хангалттай үндэсний зэвсэгт хүчинтэй байх, дайныг хязгаарлах цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг хөгжүүлэх, цэргийн хүчин чадавхаар давуу бусад улстай цэргийн эвсэл холбоо байгуулж нэгдэх, олон улсын байгууллагад энхийг сахиулах хүчний үүрэг гүйцэтгэх чиглэлд түлхүү анхаарах, дайсантай шууд зайлхийллээс татгалзаж буулт хийх буюу найр тавих болон бусад хэлбэрээр улсын аюулгүй байдлаа хангаж байна.

Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөн хийж байгаа нөхцөлийг судлан үзэхэд, дайнд бэлтгэж буй шинж тэмдгийг цаг алдалгүй илрүүлэх, гадаадын түрэмгийлэгчдийн болзошгүй үйл ажиллагаа, аюул заналыг урьдчилан тооцоолоход тусгай алба чухал үүрэгтэй болжээ. “Дайн явуулах байлдааны дүрэмд сургамжлахдаа, ... дайсан манайхыг довтлохгүй гэдэгт найдах бус, харин өөрөө бүх талаар бэлнээр дайсныг угтана гэж тооцоолох, дайсан манайд довтлохгүй гэдэгт найдах бус дайсан бидэн рүү довтлох боломжгүй байх нөхцөлийг өөрсдөө бүрдүүлэхийг хичээ”<sup>13</sup> гэснийг санаж, хамгаалах арга ухаанаа сүвэгчлэх нь чухал буй.

Дээрх судалгаа, шинжилгээний үр дүнгээс харахад, XXI зуунд хүн төрөлхтөн улам бүр нарийн төвөгтэй, олон төвт дэлхийд амьдарч байна. Хүйтэн дайны уламжлалт ойлголт хэдий өнгөрсөн зууны түүхийн хуудас болсон ч түүний шинэ хэлбэр, шинэ аргаар илрэх “өнөө үеийн хүйтэн дайн” хэмээх үзэгдэл бодит байдал дээр эргэн ирээд байна. Энэ нь гагцхүү цэрэг зэвсэг бус, харин мэдээлэл, технологи, эдийн засаг, соёлын зөрчилдөөн, нөлөөллийн төлөөх сүүдрийн өрсөлдөөнөөр илэрч буй шинэ стратегийн тулалдаан юм.

Ийм нөхцөлд ялагдахгүй байхын тулд улс орон бүр дор бүрнээ шинэ хэрэгсэл, шинэлэг арга ухааныг ашиглаж, дотоод болон гадаад сэргэмж, төлөвшил, инновацыг чухалчилж эхэлжээ. Тухайлбал:

#### 1. Мэдээллийн дархлаа ба үнэн зөв эх сурвалж

Мэдээллийн дайн бол өнөө цагийн хамгийн аюултай зэвсгүүдийн нэг болсон. Худал мэдээлэл, тролл үйл ажиллагаа, нийгмийн сүлжээгээр тархах үзэл суртлын нөлөө нь улс орны дотоод эв нэгдэл, иргэдийн итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс мэдээлэл боловсруулах чадвар, медиа боловсрол, хуурамч мэдээллийг таних чадвар нь шинэ зэвсэг болж байна.

#### 2. Технологийн бие даасан байдал

Шинэ үеийн хүйтэн дайн технологийн давуу талд тулгуурлах боллоо.

<sup>13</sup> Сун Цзы (Сун). Дайны урлаг. Ч.Улаанхүүгийн орчуулга. 2009. т.35;

Хиймэл оюун, кибер аюулгүй байдал, өгөгдлийн дүн шинжилгээ зэрэг салбарт бие даасан байх нь стратегийн чадамжийг нэмэгдүүлнэ. Улс орнууд өөрийн программ хангамж, техник технологио хөгжүүлж, гаднын хараат байдлаас гарах нь хамгийн чухал алхам болжээ.

### 3. Эдийн засгийн тэсвэртэй байдал

Худалдаа, санхүүгийн хориг, хөрөнгө оруулалтын тоглоом нь өнөө үеийн зөөлөн хүчний гол зэвсгүүдийн нэг. Эдийн засгийн бүтэц нь төрөлжсөн, уян хатан байх нь гаднын дарамтыг даван туулах баталгаа болдог. Дотоод үйлдвэрлэл, үндэсний компаниудын дэмжлэг, санхүүгийн тогтвортой байдал нь энэ дайнд тэсвэртэй байх үндэс бүрдэнэ.

### 4. Соёлын нөлөөлөл ба үндэсний дархлаа

Соёлын зөөлөн хүч, үнэт зүйлсийн дотоод бат бөх байдал нь өнөө цагийн стратегийн шинэ талбар. Гаднын соёлын нөлөөнд уусан алдахгүй байх нь үндэстний өөрийн үнэт зүйлс, уламжлал, түүхийн ухамсар, хэл соёлыг хадгалахтай шууд холбоотой. Боловсрол, урлаг, уран зохиол, хэл шинжлэл гээд олон салбараар дамжин энэ дархлаа бүрэлддэг байна.

### 5. Олон улсын хамтын ажиллагаа ба эвсэл

Ганцаар байж ялагдахгүй байх боломжгүй. Гэхдээ эвсэлд нэгдэхийн тулд үндэсний ашиг сонирхлоо уусгах биш, харин өөрийн байр суурь, үнэт зүйлсээ хадгалах шаардлагатай. Түншлэл, бүс нутгийн хамтын ажиллагаа, технологийн нэгдэл зэрэг нь стратегийн ухаалаг сонголт болоод байна.

Энэхүү “хүйтэн дайн” бидний өмнө ил, нууц хоёр фронтоор зэрэг өрнөж байгаа. Бидний хамгийн том зэвсэг бол ухаалаг бодлого, дархлаатай иргэн, тэсвэртэй эдийн засаг, инновацад суурилсан хөгжлийн стратеги юм. Ялалт бол зөвхөн тулаанд бус, урьдчилсан бэлтгэл, мэдлэг, ухамсар, хамтын хүчин чармайлтаар ирдэг.

Өнөө үеийн “хүйтэн дайн”-ыг Монгол Улсын байр суурь болон залуучуудын оролцоо гэсэн хоёр чиглэлтэй уялдуулан үндэсний онцлогийг шинжлэн гаргахыг зорилоо.

#### 1. Монгол Улсын тэнцвэрт, мэдрэмжтэй гадаад бодлогын үнэ цэнэ:

Монгол Улс нь хоёр их гүрний дунд оршдог, далайд гарцгүй, жижиг эдийн засагтай боловч гадаад бодлогодоо гуравдагч хөршийн бодлого, энх тайвныг эрхэмлэгч статусаа баримталсан, тэнцвэртэй байр суурьтай орон. Энэ бол өнөө үеийн хүйтэн дайнд ялагдахгүй байх нэгэн зөв стратеги юм.

- Гадаад орчны тогтворгүй нөхцөлд Монгол Улс түүхэн мэдрэмжтэй, геополитикийн хариуцлагатай байж, олон улсын байгууллагуудын идэвхтэй гишүүн байх, дипломат харилцаагаа олон талт болгох нь чухал.
- Цэрэг зэвсгийн оролцоог бус, дипломат, зөөлөн хүчээр оролцох

бодлого нь Монголыг энх тайвны гүүр улс болгон төлөвшүүлж байна.

- Мөн мэдээлэл, технологийн хараат бус байдал, кибер аюулгүй байдлын бодлого, үндэсний өгөгдлийн хамгаалалт зэрэг нь өнөө цагийн шинэ хамгаалалтын шугам болжээ.

“Монгол Улс хүйтэн дайны шинэ хэлбэрийн цохилтод өртөхгүйн тулд дотоод эв нэгдлээ хангаж, гадаад орчинд хэт туйлшралгүй, бодлогын ухаалаг тэнцвэрийг хадгалах нь хамгийн чухал стратеги” юм.

## 2. Залуучуудын оролцооны “дархлаа”:

Өнөө үеийн хүйтэн дайнд хамгийн их онилогдож буй бүлэг бол залуучууд болоод байна. Тэд мэдээлэл, соёл, технологийн давлагааны хамгийн идэвхтэй хэрэглэгчид учраас хамгаас түрүүнд нөлөөлөлд өртдөг. Гэсэн хэдий ч тэд бол хамгийн хүчтэй дархлаа болох боломжтой нөөц хүчин юм.

- Медиа боловсрол: Залуучууд хуурамч мэдээ, кибер халдлага, тролл үйл ажиллагааг ялган таних чадварт суралцах нь мэдээллийн дайнд ялагдахгүй байх нэг гол хүчин зүйл.
- Технологи, инновац: Монголын олон залуу стартап<sup>14</sup>, технологийн чиглэлийн компани, код бичигчид, дата аналитиктай өсөж байгаа нь дотоод инновацыг дэмжих хүч болж байна.
- Нийгмийн идэвх: Иргэний нийгмийн санаачилга, сайн дурын ажил, соён гэгээрүүлэх төсөлд оролцож буй залуус нь үндэсний үзэл, соёлын дархлааг хадгалах чухал хэсэг болно.
- Харилцаа холбоо, олон улсын боловсрол: Гадаадад сурч буй залуус Монголын талаар эерэг имиж түгээж, соёлын зөөлөн хүчийг дэлхийд таниулах томоохон элч нар юм.

“Залуус бол Монголын ирээдүй төдийгүй өнөөдрийн аюулгүй байдлын баталгаа. Тэдний мэдлэг, шүүлтүүртэй хандлага, үнэт зүйлсээ ойлгож хамгаалах ухамсар нь өнөө үеийн хүйтэн дайнд хамгийн хүчтэй ‘төрийн бус’ зэвсэг болж чадна”.

Аюулгүй байдлыг “цэргийн арга”-аар буюу стратеги, тактик, бодлого гэх ойлголтыг өнөөгийн “хүйтэн дайн”-тай уялдуулж, цэрэг зэвсгээс хальж, мэдээлэл, эдийн засаг, соёл, технологи зэрэг шинэ “байлдааны талбар”-т хэрхэн хариу өгөх талаар авч үзвэл илүү цогц, сонирхолтой өгүүлэл болгон хөгжүүлэхийг бодлоо.

Өнөө үеийн “Хүйтэн дайн”-д ялагдахгүйн тулд шинэ үеийн цэргийн

<sup>14</sup> Стартап нь шинэ санаан дээр суурилсан арилжааны төсөл, түүнийг хэрэгжүүлэхэд санхүүжилт шаарддаг. Юуны өмнө венчур сангууд гарааны бизнест хөрөнгө оруулдаг байна. Энэ бол маш эрсдэлтэй бизнес бөгөөд гарааны бизнес эрхлэгчдийн дөнгөж 1,0 хувь нь их хэмжээний борлуулалт хийж, хөрөнгө оруулагчдад өгөөжөө өгдөг гэсэн судалгаа байгаа;

урлаг ба Монголын стратеги:

Цэрэг, улс төрийн онолч Күнзийн “Дайтах урлаг” хэмээх сонгодог бүтээлд “Дайн бол хуурах урлаг” гэж онцолдог. Хүйтэн дайн ч мөн адил ил харагдахгүй, сүүдэрт өрнөдөг, шууд бус дайсагнал дээр тулгуурладаг “хуурмаг” дайн. XXI зууны энэ шинэ “сүүдрийн дайн”-д ялалт байгуулахын тулд бидуламжлалт цэргийн бодлогоос гадна мэдээллийн фронт, технологийн фронт, соёлын фронт дээр ч стратеги, тактиктэй байх шаардлагатай болжээ.

Стратеги: Үндэсний тусгаар тогтнолыг бататгах “оюун санааны хамгаалалт”

Монгол Улс бол газар нутгийн хувьд их гүрнүүдийн дунд орших, геополитикийн өндөр мэдрэмж шаардсан бүс нутагт байрладаг. Хүйтэн дайн дахин сэргэж буй энэ үед бидний стратеги бодлого дараах чиглэлүүдэд төвлөрөх ёстой:

- Гуравдагч хөршийн тэнцвэрт бодлого: Гадаад бодлого нь зөвхөн эвсэл биш, шатрын өрөг мэт тэнцвэр, итгэлцэл, олон талт харилцаа дээр суурилсан байх нь хамгаалалтын анхны шугам;
- Мэдээллийн бүрэн эрхт байдал: Гаднын санаат мэдээллийн урсгалаас хамааралгүй, дотооддоо мэдээллийн дэд бүтэц, мэдрэмжтэй медиа бодлого хэрэгжүүлэх нь орчин үеийн “хамгаалах хэрэм” болдог;

Тактик: Мэдээллийн дайн, кибер фронтод хэрхэн “байлдах” вэ? гэхэд

Цэргийн тактик нь орон зай, цаг хугацааны нягт тооцоолол, өрсөлдөгчийн алхмыг урьдаас мэдэрч хариу үйлдэл үзүүлэх ухаан юм. Орчин үеийн хүйтэн дайнд энэ нь дараах талбаруудад илэрч байна:

- Кибер аюулгүй байдал: Үндэсний өгөгдөл, төрийн мэдээллийн сүлжээ, иргэдийн хувийн мэдээллийг хамгаалах нь орчин үеийн “хил хамгаалалт”-ын нэг шинэ хэлбэр;
- Хуурамч мэдээлэлтэй тэмцэх: Нийгэмд хагарал үүсгэх зорилготой зохион байгуулалттай мэдээлэлд өртөхгүйн тулд иргэдийн мэдээллийн боловсролыг дээшлүүлэх нь стратегийн урьдчилсан цохилт гэсэн үг.

Дайны шинэ хүч: Залуусын “оюуны арми”

Орчин үеийн хүйтэн дайнд бидэнд хэрэгтэй зэвсэг бол танк, онгоц биш ухаалаг, ухамсартай иргэд, тэр дундаа мэдээлэл, технологийн чадвартай залуус юм. Залуучууд бол Монголын оюуны арми, тэд бол:

- Сэтгэлгээний дархлаа бүхий хамгаалагчид;
- Инновац бүтээгч, технологийн “инженер-цэрэг”;
- Соёлын хүчийг түгээгч элч нар.

Монголын залуус гадаадад боловсрол эзэмшиж, эх орондоо эргэн ирж байна. Тэдний оюуны чадавхыг дэмжиж, хамтдаа “сэтгэлгээний зэвсэглэлт”

хийж чадвал бид энэхүү шинэ дайнд эсрэг талын тактикийг урьдчилан мэдрэх, эсэргүүцэх, давуу байдал үүсгэх чадвартай болно.

### Дүгнэлт

Өнөө үеийн хүйтэн дайнд Монгол Улсын ялах зэвсэг бол ухаалаг стратеги, дотоод эв нэгдэл, залуусын оюуны оролцоо юм. Дайны талбар өөрчлөгдсөн ч ялах зарчим өөрчлөгдөөгүй - бэлтгэлтэй, мэдрэмжтэй, ухаалаг тал л ялахаас бус хүчтэй нь ялдаггүй.

Ялалт бол зөвхөн цохилтоор бус, бэлтгэлээр ирдэг учиртай. Бидэнд түүх, газар зүй, соёл, хүн ам зүйн сорилт байгаа ч, оюуны хүч, дижитал мэдрэмж, мэдээллийн дархлаа бий. Харин эдгээрийг зөв стратеги, нарийн бодлого, шүүмжлэлтэй сэтгэлгээгээр уялдуулж чадвал Монгол Улс XXI зууны хүйтэн дайнд ялагдахгүй, харин ухаалгаар тэсвэрлэж, өөрийн байр суурийг улам бататгаж чадна.

XXI зуунд хүйтэн дайн уламжлалт цэрэг зэвсгийн мөргөлдөөнөөс хальж, мэдээлэл, технологи, эдийн засаг, соёлын фронт руу шилжиж байна. Энэ шинэ төрлийн дайн нь улс орнуудын дотоод болон гадаад аюулгүй байдалд шууд нөлөөлж, ялангуяа жижиг, хөгжиж буй орнуудын хувьд илүү эмзэг байдлыг үүсгэж байна. Монгол Улс ч энэ шинэ нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлж, стратегийн шинэ арга барилыг хэрэгжүүлж эхлэх нь чухал болно.

Өнөө үеийн хүйтэн дайн нь зөвхөн цэрэг зэвсэг биш, мэдээлэл, технологи, эдийн засаг, соёлын фронт дээр өрнөж байна. Сүүлийн үед их гүрнүүдийн геополитикийн ил, далд өрсөлдөөн эрчимжиж өөрсдийн гео стратегийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор жижиг улс орнуудыг цэргийн хүчээр түрэмгийлэх хандлага гарч байгаа энэ цаг үед НҮБ сөргөлдөөнийг зохицуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх субъект болж чадахгүй байгаа нь хөгжиж буй орнуудын аюулгүй байдалд тулгарах аюул, эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Манай улсын цэрэг-улс төрийн гадаад орчин эмзэг, тогтворгүй, хөрш орнууд төрийнхөө бодлогоор батлан хамгаалах чадавхаа бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч, шаардлагатай тохиолдолд хилийн чанадад өөрийн эрх ашгийг цэргийн хүчээр хамгаална гэдгээ аюулгүй байдлын бодлогын баримт бичгүүддээ тусгаж, улмаар хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүд авч байна.

Өдгөө дайн болон энх тайвны зааг ялгаа бүдгэрч, уламжлалт дайн болон тайван цагийн дундын цаг хугацааны орон зай удаан үргэлжлэх болжээ. Технологийн хөгжилд тулгуурласан цэргийн бус тэмцлийн арга хэлбэр нь урд өмнө төсөөлөгдөж байгаагүй аюул занал учруулж, тайван байсан улс орныг богино хугацаанд дотоодын хямралд хүргэж, эмх замбараагүй

байдалд оруулж байна.

Өнөө үеийн шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил нь юун түрүүнд батлан хамгаалах салбарт нэвтэрч байгааг сүүлийн үеийн дэлхий дахинд болж өнгөрсөн, одоо үргэлжилж байгаа дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт томоохон өөрчлөлтүүд гарч байна.

Цаашид шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлсэн өндөр цэцтэй, хэт авианы буюу гиберсоник пуужин, дрон, роботик систем, робот, хиймэл оюун, лазер, төвлөрсөн энергийн зэвсгийн систем, кибер, мэдээллийн орон зайг сөргөлдөөнд өргөнөөр ашиглах төлөвтэй болов.

Өөрөөр хэлбэл технологи өндөр хөгжсөн улс орнууд давуу байдлаа ашиглан бусдад хяналтаа тогтоож, харин жижиг, буурай орнууд бараг хамгаалалтгүй болох эрсдэлтэй тулгарч байна.

### **Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл**

1. Клаузевиц К. О войне: трактат в 8 томах. - Том. 3. М., 1932. с. 127, 129;
2. Creveld van, M. Transformation of Warfare. New York, 1991;
3. Carver, Michael. War Since 1945. New York, 1981;
4. Laffin, John. The World in Conflict 1991. Oxford: Brassey's, 1991;
5. “Күнзийн дайтахуйн ухаан”. (М.Чимидцэеэгийн орчуулга) 2006 он., т. 22;
6. Флавий Вегеций Ренат “Краткое изложение военного дела“. /Пер. С.П.Кондратьева. // Вестник древней истории. 1940. № 1; переизд.: Греческие полиоркетики. Вегеций. (Серия «Античная библиотека». Раздел «Античная история»). СПб, Алетейя. 1996. 352 стр. с. 153-155;
7. “Дайны урлаг” (Хятад: 孫子兵法) Сун Цзы (Сун Зи);
8. “Күнз дайтахуйн ухаан”. М.Чимидцэеэгийн орчуулга. 2006 он. т. 27.
9. Ш.Паламдорж “Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хөгжлийн хандлага”. 2011 он;
10. Мао Цзэ-дун. Избранные произведения. Том 3. - М., Издательство иностранной литературы, 1953.- стр.351;
11. К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. II боть. УБ., 1970. т.488;
12. К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин “Дайн, армийн тухай”. т. 57;
13. Сун Цзы (Сун Зи). Дайны урлаг. Ч.Улаанхүүгийн орчуулга. 2009. т.35;